

## **ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

### **Ёс зүйн дүрмийн удиртгал**

Институтийн Ёс зүйн дүрэм нь дотоод аудитын мэргэжилд ёс суртахууны соёлыг төлөвшүүлэх зорилготой.

*Дотоод аудит нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бодитой баталгаажуулах ба зөвлөх үйл ажиллагаа мөн. Энэ нь эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын үйл явцын үр нөлөөт байдлыг системтэй, эмх цэгцтэй арга хандлагаар үнэлэх, сайжруулах замаар зорилтуудаа биелүүлэхэд нь байгууллагад тусалдаг.*

Ёс зүйн дүрэм нь дотоод аудитын мэргэжлийн хувьд шаардлагатай, тохиромжтой бөгөөд энэ нь түүний засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын талаарх бодит баталгаажуулалтад итгэх итгэлд суурилдаг.

Институтийн Ёс зүйн дүрэм нь дараах хоёр чухал бүрэлдэхүүн хэсгийг хамардгаараа дотоод аудитын тодорхойлолтын хүрээнээс хальдаг:

1. Дотоод аудитын мэргэжил ба практикт холбогдолтой зарчмууд.
2. Дотоод аудиторуудын зан төлвийн шаардагдах хэм хэмжээг тодорхойлсон зан суртахууны дүрмүүд. Эдгээр дүрэм нь зарчмуудыг практикт хэрхэн хэрэглэхийг тайлбарладаг бөгөөд дотоод аудиторуудад ёс зүйтэй ажиллахыг зааварлах зориулалттай.

“Дотоод аудитор” гэж Институтийн гишүүд, ДАИ-ийн мэргэжлийн гэрчилгээ эзэмшигч буюу горилогч, түүнчлэн дотоод аудитын тодорхойлолтын хүрээнд дотоод аудитын үйлчилгээ үзүүлж буй этгээдийг хэлнэ.

### **Ёс зүйн дүрмийг хэрэглэх ба мөрдүүлэх**

Энэхүү Ёс зүйн дүрэм дотоод аудитын үйлчилгээ үзүүлж буй байгууллага, хувь хүний аль алинд хамаарна.

ДАИ-ийн гишүүд болон ДАИ-ийн мэргэжлийн гэрчилгээ эзэмшигч буюу горилогчдын хувьд, Ёс зүйн дүрмийн зөрчлүүдийг Институтийн журам, Захиргааны заавруудын дагуу үнэлж, шийдвэрлэнэ. Тодорхой үйлдлийг Зан суртахууны дүрэмд дурдаагүй нь түүнийг хүлээн

зөвшөөрөмгүй буюу нэр төрд харшлахуйц байхаас халхлахгүй бөгөөд тиймээс гишүүд, гэрчилгээ эзэмшигч буюу горилогчдод сахилгын арга хэмжээ оногдуулж болно.

## **ЗАРЧМУУД**

Дотоод аудиторууд дараах зарчмуудыг баримталж хэрэглэх шаардлагатай:

### **1. Шударга байх**

Дотоод аудиторуудын шударга байдал итгэлийг бий болгох бөгөөд улмаар тэдний дүгнэлтэд тулгуурлах үндэслэл болно.

### **2. Бодитой хандах**

Дотоод аудиторууд шалгаж буй үйл ажиллагаа буюу үйл явцын талаарх мэдээллийг цуглуулах, үнэлэх, түгээхдээ мэргэжлийн бодитой хандлагыг дээд зэргээр харуулна. Дотоод аудиторууд дүгнэлтээ гаргахдаа холбогдох бүх нөхцөл байдлыг тэнцвэртэй үнэлж, өөрсдийн ашиг сонирхлын буюу бусдын нөлөөнд хэт автахгүй байна.

### **3. Нууц хадгалах**

Дотоод аудиторууд хүлээж авсан мэдээллийн үнэ цэн, өмчлөлд хүндэтгэлтэй хандаж, чингэх хуулийн буюу мэргэжлийн үүрэгтэй л биш бол холбогдох зөвшөөрөлгүйгээр мэдээллийг дэлгэхгүй.

### **4. Ур чадвартай байх**

Дотоод аудиторууд дотоод аудитын үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, туршлагатай байна.

## **ЗАН СУРТАХУУНЫ ДҮРЭМ**

### **1. Шударга байх**

Дотоод аудиторуд:

- 1.1. Ажлаа шударга, хичээнгүй, хариуцлагатай гүйцэтгэнэ.
- 1.2. Хуулийг мөрдөж, хуулиар болон мэргэжлийн хувьд шаардсан мэдээллийг дэлгэнэ.
- 1.3. Аливаа хууль бус үйл ажиллагаанд мэдсэн атлаа оролцох буюу дотоод аудитын мэргэжил, байгууллагын нэр хүндэд харшлах үйлдэлд холбогдож болохгүй.
- 1.4. Байгууллагын хууль ёсны болон ёс зүйт зорилтуудыг хүндэтгэн, хувь нэмэр оруулна.

### **2. Бодитой хандах**

Дотоод аудиторуд:

- 2.1. Голч үнэлгээг нь алдагдуулж болзошгүй буюу алдагдуулсан гэж ойлгогдох аливаа үйл ажиллагаа буюу харилцаанд оролцож болохгүй. Үүнд байгууллагын ашиг сонирхолтой зөрчилдөж болох үйл ажиллагаа буюу харилцаа хамаарна.
- 2.2. Мэргэжлийн дүгнэлтийг нь алдагдуулж болзошгүй буюу алдагдуулсан гэж ойлгогдох аливаа зүйлсийг хүлээн авч болохгүй.
- 2.3. Хэрэв дэлгэхгүй бол шалгаж буй үйл ажиллагааны талаарх тайланг гажуудуулж болзошгүй, өөрсдийн олж мэдсэн бүх материаллаг баримтыг дэлгэнэ.

### **3. Нууцыг хадгалах**

Дотоод аудиторуд:

- 3.1. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг ашиглаж, хамгаалахдаа ухаалаг хандвал зохино.
- 3.2. Мэдээллийг хувийн ашиг сонирхолд, аль эсвэл хуульд харш буюу байгууллагын хууль ёсны ба ёс зүйн зорилтуудад хор учруулахуйц байдлаар ашиглахгүй.

#### **4. Ур чадвартай байх**

Дотоод аудиторрууд:

- 4.1. Шаардагдах мэдлэг, ур чадвар, туршлагыг нь эзэмшсэн үйлчилгээнд л гагцхүү оролцоно.
- 4.2. Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартуудын дагуу дотоод аудитын үйлчилгээ үзүүлнэ.
- 4.3. Өөрсдийн мэдлэг чадвар, үйлчилгээний үр нөлөө, чанарыг тасралтгүй сайжруулна.